



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.ДАШЦЭРЭН ТАНАА

2017.02.23 № 01/40 ДУА-2017/53/СТА-ТЦЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 967,868.00 /Есөн зуун жаран долоон мянга найман зуун жаран найм/ төгрөгийн насжилт өндөртэй авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 20 дугаар зүйл 20.2.6-т /Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ Мөн хуулийн 20.2.5-т /дасны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хялах, ажлыг гүйгээг гарахаас нь өмнө хялан, баталгаажуулах / заасныг зөрчсөн.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.4-д /Байгууллага иргэдтэй үүссэн материал дүнтэй буюу насжилт өндөртэй, авлага өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй / заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах,
2. Насжилт өндөртэй авлагыг барагдуулах, хууль, хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

1700000712

3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2017 оны 03 дүгээр сарын 25-ны дотор ирүүлэхийг Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Н.Дашцэрэн/, нягтлан бодогч /Б.Өрнөхбаяр/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

ШИНЖЭЭЧ



С.ЖАЛБАА

ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА



Н.ДАШЦЭРЭН

НЯГТЛАН БОДОГЧ

Б.ӨРНӨХБАЯР

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.